

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛИЙГ ХОЁР
ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН БОЛОН МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД
ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТИЙГ ДАГАЖ МӨРДӨХӨД ШИЛЖИХ ЖУРМЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт, Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт тус тус бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Улсын Их Хурлын 2023 оны 37 дугаар тогтоол, “Улсын Их Хурлын гишүүд тойрогт ажиллах тухай” Улсын Их Хурлын даргын 2023 оны 85 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах, мэдээллээр хангах, санал бодлыг сонсох зорилгоор Улсын Их Хурлын гишүүд 2023 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 16-ны өдрүүдэд тойрогтоо ажилласан болно.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт заасныг баримтлан хэлэлцлээ.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.11 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэйгээр дэмжиж, Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлэхээр тогтлоо.


Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу зүйл тус бүрээр хэлэлцэж, төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.МӨНХЦЭЦЭГ